

БАТЛАВ

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

Б. ТӨМӨРЧӨДӨР

ЦАГААН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН

“МОНГОЛ ХЭЛНИЙ” АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024он (10 анги) 60минут Сурагчийн нэр:

Нийт: 40 оноо

А хувилбар

“Баян”

Манай сонины удирдлагын зүгээс сурвалжлагчдадаа үнэгүй цаас тараадаг байв. Бичгийн цаасыг голоор нь хуваасан шиг хэмжээтэй, үзгээр бичихээр бэх нь уусаж нэвтрээд ар тал нь үзээрийн муухай болчихдог, хямдхан тэр бор цаас сэтгүүлч бүрийн ширээн дээр овоолоотой, хамгийн үнэ цэнгүй зүйлийн нэг. Үнэ цэнгүй ч юу байх вэ, элбэг юм хямд байдаг хойно, хямд юмыг хүн үл ойшоодог хойно, мэдээж тэр цаасыг мөнгөөр л авдаг нь тодорхой ч бүгд ямар ч үнэгүй юм шиг хандана.

Би тэр үед хар бэх дүүргэсэн үзгээр өнөө муу бор цаасан дээрээ элдэв сурвалжилга, ярилцлагаа палийтал буулгахдаа дандаа л нэг талд нь бичээд, ар талыг нь хэрэглэдэггүй байв. Миний л анзаарснаар бусад маань ч тэгдэгсэн.

Нэг удаа ярилцлагаа бичиж суутал Эрдэнэсүх ах хажуугаас хараад:

-Чи яагаад цаасныхаа нөгөө талд бичихгүй байгаа юм бэ? Үнэгүй өгдөг гээд ингэж хайр гамгүй хандаж болохгүй шүү дээ! Наад цаасан дээр чинь балаар бичих юм бол бэх уухгүй, тиймээс ч арыг нь ашиглаж болдог юм. Чи таван хуудсанд багтчих юмыг арваад хуудсанд биччихлээ гэж эрсхэн хэлэв. Би тэрүүхэн зууртаа дүрсхийж, өөрийгөө өмөөрсөн хэдэн үг сөргүүлэн хэлтэл тэр:

-Том яруу найрагчдын зан юм байлгүй дээ, мэдэхгүй. Над мэтийн жирийн хүмүүс нь бол тэгж л бичдэг. Болоод л байдаг юм. Ийм их цаасыг ингэж үрж байгаа нь утгагүй хэрэг гэлээ. Ингэж хэлчхээд босоод явангуут би өөрийн эрхгүй ширээ рүү нь өнгийгөөд хартал зэмлэгч маань хаа сайгүй хэвтэж байдаг өнөө муу бор цаасныхаа ар өвөргүй жирийтэл, нэг ч зай үлдээлгүй бичсэнийг олж үзэх нь тэр ээ.

Эрдэнэсүх ахын зэмлэл надад хүчтэй нөлөөлөв. Гэрээсээ хол амьдарч яваа, ядуу оюутан миний дэргэд сургуулиа төгсөөд ирчихсэн тэр мэдээж “баян”. Учир нь би тэр үед, сурахынхаа хажуугаар ажилладаг “Ардын эрх”-ийн албан ёсны гуравхан сурвалжлагчийн нэгэн тул хагасаар цалинждаг байсан юм. Тэгээд ч Эрдэнэсүх ах миний хүүхэд насны үед хамгийн алдартай зохиолчдын нэг асан Ж.Пүрэв гуайн хүү, алдартай эцгийн хүүхдийн ёсоор надаас хамаагүй хангалуун амьдардаг нь тодорхой. Гэтэл тэр ийм хямдхан цаасыг хүртэл ариглаж хэмнэж байдаг. Эрс шулуун зэмлэл нь түүний шударга зөв сэтгэлтэйг харуулсан төдийгүй, хамгийн гол нь, бидний хувьд үнэгүй ч энэ бол бусдын халааснаас гарч байгаа үнэтэй зүйл гэсэн санаа ойлгогдсон тул би үнэнээсээ гэмшив. Бусдын эд зүйлийг хайрлаж чадна гэдэг маш том хүмүүжил юм.

Ингээд л би маргаашнаас нь цаасныхаа ар өвөргүй бичих болсон доо. Тэр, үүнийг анзаарсан эсэхийг мэдэхгүй. Юутай ч тэрхүү зэмлэлээс хойш би үрэлгэн зангаа бүрэн засаж чадаагүй ч хүнд байдаг энэ муу зангийн тухай ямагт бодож явах эхлэл тавигдсан билээ.

Байгаадаа ханах сэтгэлийг, багаар ихийг бүтээх хүчийг тэндээс олж харснаар, үргүй тэнэг зарлага, сэтгэлийн харанхуйгаас л үүддэг шунал, балчир зүрх сэтгэлтэй нэгнээс л харагддаг гялгар тансаглалд тэмүүлэх төөрөгдлөөс бага ч болов ангижирч эхэлсэн. Анзаарч л чадах юм бол эргэн тойронд маань хүчирхэг үзэл санаа, онцгой дүр төрхтэй хүн дүүрэн. Миний дээр өгүүлсэн энэ хүн бол жинхэнэ “баян” хүн байлаа. “Хэн нэг маань бурхан байдаг” гэдэг үгэнд би хэчнээн дуртай вэ!

Л. Өлзийтөгс “Үзэхийн хязгаар”-аас

1. Тэр цаасыг яагаад үнэ цэнэгүй зүйлийн нэг гэж бодсон бэ? (1 оноо)


2. 1-р цогцолбороос зохиогчийн эргэлзэж таамагласан үг хэллэгийг олж бичээрэй. (2оноо)

3. Эрдэнэсүх ах зохиогчийг юу гэж зэмлэсэн бэ? (2 оноо)

4. Эхэд байгаа доорх үг хэллэгийн утгыг тайлбарлаарай. (3 оноо)
хагасаар цалинжих
.....
асан
ангижир
5. Зохиогч Эрдэнэсүх ахыг юу гэж дүгнэсэн бэ? (3 оноо)

6. “. . .Энэ хүн бол жинхэнэ баян хүн байлаа” гэж дүгнэсний шалтгааныг 20-30 дугаар мөрнөөс олоод, 40-50 үгэнд багтаан тайлбарлан бичээрэй. (5 оноо)

7. Монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлээрэй. (5 оноо)



8. Дүрс ялган бичих үгийг утгатай нь харгалзуулаарай. (Тохирохгүй 1 утга үлдэнэ.) (4 оноо)

1. 2. 3. 4.
-

- A. Өнөөх
 B. Өнө эрт
 C. Өвлийн өн
 D. Өнөө үе
 E. Үнэ ханш

9. Хүснэгт дэх мэдээлэл баримт уу, үзэл бодол уу? Зөвийг сонгож тэмдэглээрэй. (5 оноо)

№	Мэдээлэл нь	Баримт	Үзэл бодол
a	Монгол бичгийг төрийн бичиг болгох сэргээн хэрэглэх бүх нийтээрээ эзэмших тухай бүхий л шатанд ихэд ярьж хэлэлцсээр байгаа боловч үр дүн нь хангалттай бус байна.	1	2
b	Еврэй хэл Англиар Hebrew оросоор еврей, еврит (ичих) симит язгуурын хэл. Израйл улсын албан ёсны хэл бөгөөд 7 сая гаруй хүн хэлэлцдэг.	1	2
c	Монгол бичгийн хэрэглээ 1990-ээд оныхоо байранд зогссоор байна гэхэд хилсдэхгүй.	1	2
d	Энэ нь монгол бичгийнхээ сайн мууд байгаа биш үндэстний сэтгэлгээ, идэвх, эх оронч үзэл, өөрийгөө хамгаалах зөн зэрэг зүйлээс хамааралтай юм.	1	2

e	МЭӨ 3 дугаар зууныг хүртэл Палестин орчимд хэлэлцэгдэж байгаад зөвхөн бичгийн хэл болж үлдсэн боловч 19 дүгээр зуунаас ахин амьд ярианы хэл болон сэргэсэн түүхтэй.	1	2
---	---	---	---

10. Өгүүлбэрүүдийг дүрслэх ур маягтай нь зөв харгалзуулаарай. (5 оноо)

- | | |
|--|--------------|
| a. Олон дайнд оролцон чадал хүчиндээ эрдэж явснаа санахад чиний илдийн дор явж би хэзээ ч чадахгүй. | 1. Адилтгал |
| b. Үндэс мөчир бөхтэй Хорхоногийн саглагар мод шиг цэцэглэн ганхаж явсан юм сан. | 2. Амьдчилал |
| c. Тэр газрын цээжийг аниртан чагнаваас монгол эрсийн нөхөрлөл, гунигт хагацлын тухай эмгэнэлт түүхийг өгүүлнэ. | 3. Хэтрүүлэл |
| d. Тунгалаг мөрөн зөөлөн зөөлнөөр дув дуугүй урсах дор | |
| e. Ялгуун саарал морин нь тогтож ядан, гуа сайхан дөрвөн хөлөөр ээлжлэн газар цавчилж, уран сайхан толгойгоо ийш тийш сэжихүй нь агаар дор дэгдэж, үүлэн дор умбан алдана. | 4. Төлөөлөл |

11. Дараах зохиолуудыг зохиолчтой нь зөв харгалзуулаарай. (5 оноо)

- | | |
|------------------------------|------------------|
| a. “Жамухын өчил” | 1. Д. Нацагдорж |
| b. “Хар ус нуурын шагшуурга” | 2. Д. Равжаа |
| c. “Ламбагауйн нулимс” | 3. Д. Намсрай |
| d. “Дөрвөн улирал” шүлэг | 4. Ж. Саруулбуян |
| e. “Бодончар богд” | 5. Б. Явуухулан |

БАТЛАВ

СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ

Б. ТӨМӨРЧӨДӨР

ЦАГААН-ОВОО СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН

"МОНГОЛ ХЭЛНИЙ" АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024он (10 анги) 60минут Сурагчийн нэр:

Нийт: 40 оноо **В** хувилбар

"Ядуу"

"Хэн нэг маань бурхан байдаг" гэдэг үгэнд би хэчнээн дуртай гээч! Байз, байз, хэн нэг маань бурхан юм чинь тэгэхээр хэн нэг маань чөтгөр болж таарах нь уу?

Саяхны өдрүүдэд би нэгэн эхнэртэй танилцав. Тэрээр манай толгой баячуулын нэгнийх нь гэргий байж, хөөрхий. Гэрээс цухуйдаггүй би анх танилцахдаа үүнийг нь мэдсэнгүй. Түүнтэй, өөрийнх нь хүсэлтээр яг дөрвөн удаа уулзсан агаад шинэхэн танилдаа би нэгэн хочийг өгснөөр бидний нөхөрлөл дуусаж билээ. Түүнийг "Ахиад" гэдэг нэрээр гар утсан дээрээ тэмдэглэчихсэн юм.

"Би саяхан LV-ийн таван сая төгрөгийн үнэтэй цүнх авсан, ахиад өөрийг авах гэж байгаа. Би өнгөрсөн жил улаан өнгийн Ланд машинтай болсон юм л даа. Ирэх жилээс ахиад харыг авах санаатай. Би саяхан нүүрнийхээ арьсыг татуулсан. Одоо ахиад хүзүү, гарынхаа арьсыг татуулмаар байна" гэж ярьдаг хүн байв аа тэр. Түүний үгсийн санд байдаг хамгийн түгээмэл үг бол "ахиад". "Ахиад" эмэгтэй цонхигор гэдэг үгийг ойлгохгүй надаар тайлбарлуулж билээ. Таван сая төгрөгийн цүнхэнд гар татдаггүй танил маань таван мянган төгрөгийн ном надаас бэлгэнд авчхаад "Ахиад өөр ном байна уу?" хэмээн шалав. Өмнөх номыг маань огт уншаагүйг нь мэдэх болохоороо ахиад өгсөнгүй. Шинэхэн танилынхаа тогтож ядсан, шунамгай гүйлгээ нүд рүү удаан хараад "Хөөрхий дөө, энэ эмэгтэй бага насандаа маш их ядуу зүдүү өссөн, өлсөх, гачигдах, бусдын эд зүйлд татагдан харуусахын туйлыг амссан, ядуу зүдүүдээ хүн болгон эмзэглэдэггүй ч тэрээр үргэлж тийм байдлаасаа ичиж, цөхөрч явсан нэгэн бололтой" хэмээн таамаглахад хүрсэн сэн. Тийм хүн л мөнгөтэй болсон ч үүрд өлсгөлөн үлддэг, баяжсан ч мөнхөд ядуугаараа хоцордог билээ.Өлссөн хүн ходоодныхоо хэмжээг мэдэлгүй иддэг. Өлсгөлөн тархи "хязгаар" гэдэг үгийг санадаггүй.

"Ахиад" эмэгтэйгээс уйдаж залхаад би түүний мөрөөдлийн биелэл болсон "зиндааны" хүн бишээ ойлгуулахаар шийдэв.

-Аан, надад тийм юм байхгүй ээ. Булган хүрэм бол бүүр ч байхгүй. Байхгүй ээ, байхгүй. Өө, надад ердөө ганцхан цүнх бий.

"Ахиад" бүр гайхаж хоцров. Сүүлдээ ч намайг голох шиг боллоо. Ахиад залгахаа болив, ашгүй.

Хүн заавал чинээлэг амьдрах ёстой юм шиг боддогосоо болоод ядуу байдалдаа эмзэглэн ичсэн гунигт нүдтэй бид хаа сайгүй тулгардаг. Басхүү, хангалуун амьдралтай нэгнийг үзэн ядсан харц, тансаг эд зүйлээр гайхуулсан мунхаглал, дуусашгүй их атаа жөтөө, өрсөлдөөн тэмцэлдээн энд тэндгүй. Тийм хүмүүсийн өөдөөс, тийм байдлын өөдөөс би инээд алдан байж "Надад бол байхгүй ээ!" гэж хэлэхдээ одоо хэчнээн дуртай болсон гээч! Энэ "БАЙХГҮЙ" бол миний нүүр бардам "цэвэр" амьдрал, онигор нүдтэй маань хамт бурхнаас

надад заяасан төрөлхийн ханал цадал, түрийвч минь хоосон үед ч дүв дүүрэн явуулдаг тэр л байгаа юм. Би одоо гурван даашинзтай байхаас нэг даашинзтай байхыг илүү үздэг.

Харанхуйгаас л үүддэг шунал, балчир зүрх сэтгэлтэй нэгнээс л харагддаг гялгар тансаглалд тэмүүлэх төөрөгдлөөс бага ч болов ангижирч эхэлсэн. Миний дээр өгүүлсэн энэ хүн бол жинхэнэ “ядуу” хүн байлаа.

Л. Өлзийтөгс “Үзэхийн хязгаар”-аас

1. Зохиогч шинэ танилтайгаа нийт хэдэн удаа уулзсан бэ? (1 оноо)

2.Саяхны өдрүүдэд тэмдэглэчихсэн юм. Хүртэлх хэсгээс зохиогч шинэ танилаа үл ойшоосон өнгө аясыг илэрхийлсэн үг хэллэгийг олоорой. (2 оноо)

3.Шинэ танилаа хочлох болсон шалтгаан юу вэ? (2 оноо)

4.Эхэд байгаа доорх үг хэллэгийн утгыг тайлбарлана уу? (3 оноо)

цонхигор


гар татдаггүй.....

шалах

5. Зохиогч “Ахиад” эмэгтэйн нүднээс ямар дүгнэлт хийсэн бэ? (3 оноо)

6. “. . .Энэ хүн бол жинхэнэ ядуу хүн байлаа.” гэж дүгнэсний шалтгааныг 40-50 үгэнд тайлбарлан бичээрэй. (5 оноо)

7. Монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлээрэй. (5 оноо)



8. Дүрс ялган бичих үгийг утгатай нь харгалзуулаарай. (Тохирохгүй 1 утга үлдэнэ.) (4 оноо)

1. 2. 3. 4.

- A. Өнөөх
 B. Өнө эрт
 C. Өвлийн өн
 D. Өнөө үе
 E. Үнэ ханш

9. Хүснэгт дэх мэдээлэл баримт уу, үзэл бодол уу? Зөвийг сонгож тэмдэглээрэй. (5 оноо)

№	Мэдээлэл нь	Баримт	Үзэл бодол
a	Монгол бичгийг төрийн бичиг болгох сэргээн хэрэглэх бүх нийтээрээ эзэмших тухай бүхий л шатанд ихэд ярьж хэлэлцсээр байгаа боловч үр дүн нь хангалттай бус байна.	1	2
b	Еврэй хэл Англиар Hebrew оросоор еврей, еврит (ичих) симит язгуурын хэл. Израйл улсын албан ёсны хэл бөгөөд 7 сая гаруй хүн хэлэлцдэг.	1	2
c	Монгол бичгийн хэрэглээ 1990-ээд оныхоо байранд зогссоор байна гэхэд хилсдэхгүй.	1	2
d	Энэ нь монгол бичгийнхээ сайн мууд байгаа биш үндэстний сэтгэлгээ, идэвх, эх оронч үзэл, өөрийгөө хамгаалах зөн зэрэг зүйлээс хамааралтай юм.	1	2

е	МЭӨ 3 дугаар зууныг хүртэл Палестин орчимд хэлэлцэгдэж байгаад зөвхөн бичгийн хэл болж үлдсэн боловч 19 дүгээр зуунаас ахин амьд ярианы хэл болон сэргэсэн түүхтэй.	1	2
---	---	---	---

1. Өгүүлбэрүүдийг дүрслэх ур маягтай нь зөв харгалзуулаарай. (5 оноо)

- | | |
|--|--------------|
| a. Олон дайнд оролцон чадал хүчиндээ эрдэж явснаа санахад чиний илдийн дор явж би хэзээ ч чадахгүй. | 1. Амьдчилал |
| b. Үндэс мөчир бөхтэй Хорхоногийн саглагар мод шиг цэцэглэн ганхаж явсан юм сан. | 2. Адилтгал |
| c. Тэр газрын цээжийг аниртан чагнаваас монгол эрсийн нөхөрлөл, гунигт хагацлын тухай эмгэнэлт түүхийг өгүүлнэ. | 3. Төлөөлөл |
| d. Тунгалаг мөрөн зөөлөн зөөлнөөр дув дуугүй урсах дор
e. Ялгуун саарал морин нь тогтож ядан, гуа сайхан дөрвөн хөлөөр ээлжлэн газар цавчилж, уран сайхан толгойгоо ийш тийш сэжихүй нь агаар дор дэгдэж, үүлэн дор умбан алдана. | 4. Хэтрүүлэл |

2. Дараах зохиолуудыг зохиолчтой нь зөв харгалзуулаарай. (5 оноо)

- | | |
|------------------------------|------------------|
| a. “Жамухын өчил” өгүүллэг | 1. Б. Явуухулан |
| b. “Хар ус нуурын шагшуурга” | 2. Д. Равжаа |
| c. “Ламбагауйн нулимс” | 3. Ж. Саруулбуян |
| d. “Дөрвөн улирал” шүлэг | 4. Д. Намсрай |
| e. “Бодончар богд” өгүүллэг | 5. Д. Нацагдорж |